


Хадгаламж зээлийн хоршоо гэж юу вэ?

Эдийн засаг, нийгмийн болон соёлын нийтлэг хэрэгцээгээ хангар зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, ардчилсан хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээ болон хуулиар зөвшөөрсөн санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг ХАДГАЛАЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО гэнэ.

Хадгаламж, зээлийн хоршооны удирдлага, зохион байгуулалт:



Бүх гишүүдийн хурал нь хоршооны удирдах дээд байгууллага бөгөөд ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа тэргүүлэгчид зарлан хуралдуулж байх ёстой. Мөн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санаачлага гарган бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн:

Тухайн хадгаламж зээлийн хоршооны дүрмийг хүлээн зөвшөөрсөн, холбогдох хариуцлагыг хүлээх чадвартай иргэн нь сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж, хоршооны үйлчилгээг авах эрхтэй болно.

<u>Гишүүний эрх:</u>	<u>Гишүүний үүрэг:</u>
бүх гишүүдийн хуралд саналын нэг эрхтэй оролцох;	хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд оролцож, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, түүний санхүү, эдийн засгийн болон хөрөнгийн байдал, жил, улирлын санхүүгийн тайлан, мэдээ, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, тэдгээрийн үйл ажиллагааны тайлан, бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэлтэй тогтмол танилцах;
бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах саналыг гаргах;	хувь хөрөнгийг тогтоосон хугацааны дотор оруулах;
тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүнийг сонгох, сонгогдох;	хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох, бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэрийг биелүүлэх;
гишүүнчлэл бүхий хадгаламж, зээлийн хоршоондоо мөнгөн хөрөнгөө хадгалуулах, зээл авах болон бусад үйлчилгээнд хамрагдах;	хадгаламж, зээлийн болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөлийн хууль бус үйл ажиллагааны талаар Хороонд гомдол гаргах;

гишүүний бүртгэлд тусгагдсан мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр шуурхай мэдэгдэх.

гишүүнчлэлээс гарах;

энэ хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон хязгаарын хүрээнд хувь хөрөнгө оруулах, өөрийн оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хөрөнгө авах;

хадгаламж, зээлийн хоршоо татан буугдсан тохиолдолд үлдсэн эд хөрөнгөөс оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хөрөнгө авах;

өөрийн оруулсан хувь хөрөнгөө хууль, журмын дагуу бусдад шилжүүлэх, өв залгамжлуулах;

хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад эрх.